

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИЖ БУЙ “АЛСЫН ӨРТӨӨ” ХХК-ИЙН “ХАЯГДАЛ
ТӨМӨРЛӨГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР
2025

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр.....	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч	3
1.3. Төслийн байршил.....	3
1.4. Төслийн танилцуулга.....	4
1.5. Төслийн зорилго.....	4
1.6. Төслийн хүчин чадал.....	5
1.7. Үйлдвэрийн технологи	5
1.7.1. Үйлдвэрийн үндсэн дамжлага	5
1.7.2. Төслийн үндсэн ба туслах материалын орц найрлага	6
1.8. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил.....	7
2. ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ.....	8
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	10
3.1. Төслийн нөлөөллийн тодорхойлолт.....	10
3.2. Төслийн болзошгүй нөлөөллийг тодорхойлох.....	10
3.2.1. Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлсон үр дүн.....	10
3.2.2. Байгаль орчны үнэлгээний нэгтгэл	14
4. 2025 ОНД АШИГЛАХ ХИМИЙН БОДИС	17
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО	18
5.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	18
5.1.1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	18
5.1.2. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .	19
5.1.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
5.1.4. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
5.2. Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	19
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
7. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
9. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
10. АЖИЛЧДЫН ЭРҮҮЛ МЭНДЭД УЧРУУЛАХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ.....	26
11. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	27
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	29
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	31
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	32
15. ДҮГНЭЛТ	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үйлдвэрийн хүчин чадал.....	5
Хүснэгт 2. Ган туйвангйн түүхий эд материалын орц, норм.....	6
Хүснэгт 3. Цахилгаан нуман зуухны хайлалтын горим	7
Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, түүний үнэлгээ.....	14
Хүснэгт 5. Болзошгүй сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр.....	15
Хүснэгт 6. 2025 онд ашиглах химийн бодисын жагсаалт	17

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	3
Зураг 2. Төслийн талбай орчны зураг фото зураг	4
Зураг 3. Монгол орны физик газарзүйн мужлалтын зураг	8
Зураг 4. Төслийн талбайн өндөржилт, налуужилтын зураг	9
Зураг 5. Төслийн нөлөөллийн бүс	10
Зураг 6. Орчны хяналт шинжилгээний цэгүүд.....	20
Зураг 7. Ногоон байгууламж, тарималжуулалт хийх байршил	20



Зураг 2. Төслийн талбай орчны зураг фото зураг

1.4. Төслийн танилцуулга

“Алсын өртөө” ХХК-ийн үйлдвэр нь MNS JIS G 3112:2002 стандартын чанарын шаардлага хангасан ган туйванг ашиглан амины орон сууцнаас эхлээд олон давхар иргэний болон үйлдвэрийн злоиулалттын барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн байгууламжууд болон бүх төрлийн төмөр бетон хийц, эдлэлийг богино хугацаанд угсрах, үйлдвэрлэх боломжтой.

1.5. Төслийн зорилго

“Алсын өртөө” ХХК нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу чанар стандартыг баримтлан ажиллаж хаягдал төмөрлөг ашиглан барилгын арматурын төмөр үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлэх ба байгальд хатуу хог хаягдал бага гаргах, ажлын байр нэмэгдүүлэх гэх мэт нутгийн ард иргэдийн үр ашгийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

1.6. Төслийн хүчин чадал

“Алсын өртөө” ХХК-ийн “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төсөл нь 2015 онд “Мон Газар Экологи” ХХК-иар Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн бөгөөд БОННУ-ний нэмэлт тодотгол ажлын хүрээнд тус “Мон Газар Экологи” ХХК-аар Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлыг хийлгэж байна.

Тус үйлдвэрийн хүчин чадал нь өдөрт 30 тн, сард 900 тн, жилд 2000 тн ган туйван үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Үйлдвэр нь жилд 207 өдөр ажиллаж 112 ажилтан байх ба нэг элжиндээ 112 хүн ажиллана.

Хүснэгт 1. Үйлдвэрийн хүчин чадал

№	Нэр	Үзүүлэлт
1	Үйлдвэрийн жилд ажиллах хугацаа, хоног	270
2	Нийт ажиллах хүний тоо	112
3	Хоногт ажиллах элжийн тоо	2
4	Нэг ээлжинд ажиллах хугацаа, цаг	10
5	Бүтээгдэхүүний төрөл	Ган туйван
6	Жилд	2000 тн
7	Сард	900тн
8	Өдөрт	30тн

1.7. Үйлдвэрийн технологи

Ган туйвангийн бэлдэц үйлдвэрлэх гангийн хайлуултанд орох үйцийн материалууд, төмөр хэв хийх материалууд гол түүхий эд материал нь болно. Ган туйвангийн бэлдэцийн хэвийг металаар хийдэг. Металл хэвээ голдуу саарал болон бат бөр ширэмээр хийнэ. Үүнд: СЧ20 ба СЧ25 болон ВЧ12-42, ВЧ5-45 маркийн ширмүүд байна. Мөн бага болон дунд зэрэг чанаржуулсан гангаар хийж болно.

1.7.1. Үйлдвэрийн үндсэн дамжлага

Үйлдвэрийн үндсэн дамжлагууд нь түүхий эд материалг бэлтгэх, ган хайлах, бэлдэц цутгах, бэлдэтцийг дахин халаах, халуунаар цувих, бэлэн бүтээгдэхүүнийг савлах ачилтад бэлдэх гэсэн үндсэн 5 даван дамжлагаас бүрдэнэ.

Ган хайлах дамжлагад 1 цаг 30 минутад 4 тн ган хайлах хүчин чадалтай 2 иж бүрэн цахилшааг нуман зуух ашиглана. Хоногт нэг зуух нь хоёр ээлжээр ажилан 6 удаа хайлж 60 тн 2 зуух 120 тн ган бэлдэц үйлдвэрлэнэ.

Ээлжиндээ 1 зуух 240 тн, 2 зуух 480 тн ган бэлдэц үйлдвэрлэх хүчин чадалтай. Нуман зууханд хайлан хагдал төмрийг жигнэж шууд өгөх ба харин хаягдал төмрийг төмрийг төмөр бэлтгэх хэсэгт хийн болон бензин зүсэгч, гидро хайчаар тайрч бэлтгэн зууханд өгнө.

Ангижуулагч нэмэлтүүдийг электрон жингээр жигнэж хийнэ. Халуун хайлмаг ганг засварын хувинд юүлхэхийн өмнө дээж авч фото эмиссийн спектрометрээр гангийн химийн хайрлагыг 1-2 минутап тодорхойлж химийн найрлага стандартын хэмжээнд байгаа тохиолдолд ганг юүлнэ. Хэрэв химийн найрлага тохирохгүй бол зохих намэлтийг хийнэ. Хайлалт бүрт спектрометрээр гангийн найрлагын хянаж байгаа болохоор үйлдвэрээс гарч байгаа бүтээгдэхүүн стандартын шаардлагыг бүрэн хангах үндсэн нөхцлийг бүрдүүлж байгаа болно.

Бэлдэц цутгах дамжлага хэвтээ цутгуурын машиныг ашиглана.

Дахин халаах дамжлага дээр цахилгаан индукцийг халаагуур ашиглана. Энэ нь нүүрс шатаахгүй, ажлын орчныг сайжруулна.

Халуунаар цувих дамжлага дээр зэрэгцээ ба цуваа байрлалтай БНХАУ-д үйлдвэрлэсэн цувих машиныг ашиглана. Цувих төхөөрөмж нь бүдүүн цувилтын 1-р дамжлага, нарийн цувилтын 2-р дамжлага гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Цувих дамжлага нь хоногт 1 ээлжээр 12 цаг ажиллана. Халуунаар цувиад гарсан арматурын хөргөх тавцан дээр 0,5 цаг хөргөнө.

Бэлэн бүтээгдэхүүний талбай дээр ган туйвангаас дээж авч механик шинжилгээг лабораториор хийж дүгнэлт гаргасны дараа тайрч, баглах, хаяг зуух, жигнэж бэлдэх ажлууд хийгдэнэ. Бэлэн бүтээгдэхүүнийг ямаан кранаар тээврийн хэрэгсэлд ачина.

Ган туйвангийн бэлдэц үйлдвэрлэх технологийн бүдүүвч

1. Хаягдал төмрийг жигнэж хүлээн авах
2. Хаягдал төмрийг ангилж, ялгах
3. Хаягдал төмрийг цэвэрлэж бэлтгэх
4. Хаягдал төмрийг жигнэж хайлалтад бэлтгэх
5. Ган хайлалт
6. Цахилаан нуман зууханд ганг хайлсаны дараа ангижруулалт хийх
7. Хаягдал ган төмөр халуун хайлмаг болох үед хатуу хаягдал шлак /төмрийн хөлс/ үүснэ
8. Шлак нь даоаар ислүүдээс бүрдэнэ.

Исэл	CaO	SiO ₂	MgO	Al ₂ O ₃	MnO	FeO	CaF ₂	CaS	CaO/SiO ₂
%	55,0	20,0	10,0	3,0	0,1	0,4	10,0	10,0	2,75

9. Ангижруулалт
10. Лабораторийн хяналт
11. Ган туйвангийн бэлдэц цутгалт
12. Бэлдэцийн хөрөглт
13. Цувилт
14. Хөргөлт
15. Гангийн химийн найрлагыг тодорхойлох
16. Механик үзүүлэлтийг тодорхойлох
17. Гологдол бүтээгдэхүүн
18. Сав баглаа боодол
19. Ган туйвангийн багц бүрт MNS JIS G 3112:2002 стандартын дагуу дараах мэдээллийг агуулсан шошго зүүнэ.
 - Үйлдвэрдэгчийн нэр ба компанийн лого
 - Стандартын дугаар
 - Ангилал
 - Нэрлэсэн голч
 - Ган туйвангийн урт, багц дахь тоо ширхэг, нийт жин хайлалтын дугаар он сар
20. Хэрэглэгчдэд дагалдуулах чанарын сертификат

1.7.2. Төслийн үндсэн ба туслах материалын орц найрлага

Ган туйвангийн марк, хэрэглэж байгаа түүхий эдийн шинж чанар, үйлдвэрлэлийн технологийн онцлогтой уялдуулан тооцоо туршилтын аргаар ангилал тус бүрээр тогтоож компанийн захирал батлан мөрдүүлнэ.

Хүснэгт 2. Ган туйвангийн түүхий эд материалын орц, норм

№	Зардал	Хэмжих нэгж	1 тн-ийн орц	Жилд шаардагдах хэмжээ
1	Хаягдал хар төмөр		1.5	9000
2	Цахилгаан эрчим хүч	Квт.цаг	1400	42000000
3	Ус	Куб.метр	0.3	9000
4	Кварцит	Кг	12	360000
5	Графит			18000
6	Борын хүчил	Кг	0.3	9000
7	Ферромарганец, 75%	Кг	14	420000
8	Ферросилиций, 75%		6	180000

9	Шингэн шил			30000
10	Хучилтөрөгч	М	7	70000
11	Пропан	М	0.3	9000
12	Сэлбэг	Төг	2500	75000000

Хүснэгт 3. Цахилгаан нуман зуухны хайлалтын горим

Зуухны багтаамж	2000 кг
Хайлах хугацаа	90 мин
Генераторын хүчин чадал	1850 кВт
Температур өгсөх хүчин чадал	2100 кВт
Температур өгсөх хугацаа	20 мин
Температур өгсөх хугацаа	30 мин
Температур буулгах хугацаа	20 мин
Температур буулгах чадал	500 кВт

Түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт

Үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийг борлуулахдаа авто тээвэр ашиглах бөгөөд технологийн түүхий эдүүдийг гэрээт байгууллагуудаас өөрийн тээврээр авчирна. Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний талбай, импортын тус лах материалын агуулахад одоо байгаа талбайг ашиглана.



1.8. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Авто зам: Уг төслийн талбай нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар-Дархан-Сэлэнгэ чиглэлийн хатуу хучилттай замаас салан 100 м хатуу хучилттай замаар зорчин хүрнэ. Дэд бүтэц сайн хөгжсөн, авто замын сүлжээнд холбогдсон байна.

Усан хангамж: Тус төсөл хэрэгжүүлэгч “Алсын өртөө” ХХК нь ахуйн хэрэгцээ болон хэрэгцээний усыг өөрийн эзэмшлийн талбайд байрлах гүний худгаас хангана.

Дулаан хангамж: Ажилчдын байрны халаалтад цахилгаан халаалтын систем суурилуулан хэрэгцээг хангадаг байна. Өвөл ажиллахгүй.

Цахилгаан хангамж: Тус үйлдвэр нь цахилгаан эрчим хүчний хангамжийг Дархан-Сэлэнгийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ХК-ны техникийн зөвлөлөөс олгосон техникийн нөхцөлийн дагуу Зүүнхараа 110/35/10 КВ-ын дэд станцаас 35/10 кВ-ын 10000 кВА-ийн шугамаар тэжээл авна.




Зураг 4. Төслийн талбайн өндөржилт, налуужилтын зураг

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ширхэнцэг 2-р багийн нутагт, Зүүнхараа суурины баруун өмнөд захад байрлах “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төслийн танилцуулга болон бусад холбогдох бичиг баримтыг нарийвчлан судалж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ЖУРАМ”-ын дагуу дараах алхмаар тодорхойлов.

3.1. Төслийн нөлөөллийн тодорхойлолт

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар тогтоохдоо нөлөөлөл буурах функцийг ашигласан болно. Нөлөөллийн эх үүсвэрүүд төслийн талбайн хилээс хүчтэй нөлөөлөл 50 м зайд, дунд зэргийн нөлөөлөл 100 м зайд, бага нөлөөлөл 150м зайд тус тус үүсэхээр байна.



Зураг 5. Төслийн нөлөөллийн бүс

Төслийн талбайн баруун талд Баянсуудал шүтээн ХХК, НИК ХХК Дархан-Уул аймаг дахь салбар, талбайн хойно Монгол-Оросын-Хувь-Нийлүүлсэн-Нийгэмлэг-Улаанбаатар-Төмөр-Зам, 4303012204 нэгж талбарын дугаар бүхий Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар, талбайн зүүн талд 4303011710 нэгж талбарын дугаар Худалдаа, Содмонгол групп ХХК Төв салбар, төслийн талбайн урд Тэс петролиум, Дашваанжил ХХК, Горгаз ХХК төв салбар зэрэг газрууд үйл ажиллагаа явуулж байна.

3.2. Төслийн болзошгүй нөлөөллийг тодорхойлох

3.2.1. Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлсон үр дүн

Аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах үеийн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, эдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, түүний эрчим зэргийг тодруулахын тулд байгаль орчны үнэлгээний ажилд магадлан жагсаах аргыг (checklist) өргөн ашигладаг.

Р.Мижиддорж нар байгаль орчны үнэлгээнд магадлан жагсаах аргыг ашиглах 2 хувилбарыг нэгтгэсэн байдлаар боловсруулсан байдаг /Р. Мижиддорж, 2002 он/. Үүнд:

А. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал. Энд байгаль экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор, эдийн засаг, нийгмийн асуудал, бусад асуудал гэсэн хэсэг бүрт хамаарах нөлөөллийн хэлбэр (шууд, шууд бус), хугацаа (богино болон урт хугацааны), нөлөөллийн эрчим (хүчтэй, дунд зэрэг, бага)-ийг харуулсан магадлах жагсаалтыг нэрлэж болно.

Б. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой нөлөөллийн магадлан жагсаалт. Үүнд: Төслийн байршил, уг төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой нөлөөлөл, мөн барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудал, төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуур буюу бодлогын чанартай асуудалд хамаарах үйлдвэр аж ахуйн газрын нөлөөллийн эрчмийг заасан байдаг.

А. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал

Байгаль экосистемийн өөрчлөлт:

Төслийн үйл ажиллагаагаар ахуйн хэрэгцээний усыг төвлөрсөн системээс технологийн хэрэгцээний усыг өөрийн эзэмшлийн талбайд байрлах гүний худгаас хангана. Төслийн үйл ажиллагаагаар хүн, машин техникийн хөдөлгөөн ихсэх зэргээс төслийн талбайд байгаль экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрс, ургамалд шууд нөлөөлнө. Энэ нь төслийн талбайн хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг барилга, байгууламжид дарагдах, талбайн хөрс хүнд машин техникийн нөлөөгөөр дагтарших, ургамлан бүрхэвч талхлагдах, тухайн орчны өнгөн хөрс элэгдэл, эвдрэлд орох зэрэг болно.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт:

“Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төсөл нь түүхий эдээ байгалаас авч ашиглахгүй тул байгалийн баялагт нөлөөлөлгүй болно. Төслийн түүхий эдийг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаас ханган нийлүүлэх нь зүйтэй. Төслийн ажилчдын унд ахуйд цэвэр ус хэрэглэгдэнэ.

Төсөл хэрэгжих талбайн орчим ой мод, ус намгархаг газар байхгүй. Суурьшлын бүсэд хэрэгжих байгаа учир дуу чимээ зэргээр хөрсний амьтдад нөлөөлөл үзүүлэх, ургамлан нөмрөгийг доройтолд оруулах боловч ургамал, амьтны нөөцийг шууд ашиглахгүй тул биологийн олон янз байдалд нөлөөлөх нь бага байна.

Байгаль орчны чанарын өөрчлөлт:

Хатуу, шингэн хаягдлыг холбогдох журам, стандартад заасны дагуу зайлуулаагүй нөхцөлд хөрс, газрын доорх усыг бохирдуулах эрсдэлтэй. Төслийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөр дэхь шаталтаас агаар орчинд хийн хаягдал үүснэ. Төслийн талбайн ойр орчимд үйлдвэр үйлчилгээ хөгжсөн бүсэд хэрэгжих учир дуу чимээ харьцангуй өндөр. Ахуйн шингэн хаягдал, шатах тослох материалын нөлөөгөөр хөрсний чанарт өөрчлөлт орж болзошгүй.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, археологи, палеонтологийн олдвор:

Ажилчдад байгаль хамгаалах талаар сургалт сурталчилгаа хийгдээгүй, хангалтгүй нөхцөлд төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр орчмын хөрс, ургамлын нөмрөг талхлагдах, доройтох нөлөөлөл үзүүлж болзошгүй. Төсөл нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжихгүй. Үйлдвэрлэл явуулж буй талбайд түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн ховор олдворын зүйл байхгүй учир төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлгүй болно.

Эдийн засаг, нийгмийн асуудал:

Эрдэс бордооны агуулах төсөл хэрэгжсэнээр ажлын байр нэмэгдэнэ. Орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний татвар төлнө. Тодорхой тооны иргэдийг ажлын байраар хангах, тэдний амьжиргаанд тус нэмэр болох, ядуурлыг бууруулахад дэмжлэг болохоос гадна дэд Хөдөө аж ахуйн салбарт нөлөөлөх зэрэг эерэг нөлөөллүүд гарна.

Бусад нөлөөлөл:

Төсөл нь үйл ажиллагаандаа хор аюулын зэрэг өндөртэй химийн бодис ашиглахгүй. Хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих зэргээс урьдчилан сэргийлж, халдваргүйжүүлэх, нян устгах ариутгалыг тогтмол хугацаанд хийж байх нь зүйтэй. Төсөл хэрэгжих явцад ажилчдын хариуцлагагүй байдал, болгоомжгүй үйлдлээс үүдэн гал түймэр гарч болзошгүй. Тухайн үед яаралтай арга хэмжээ аваагүй нөхцөлд байгаль орчинд их хэмжээний хохирол учруулахаас гадна нийгэм, эдийн засгийн хувьд ч хүчтэй сөрөг нөлөө үзүүлнэ.

№	Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөллийн хэлбэр			Үргэлжлэх хугацаа		Нөлөөллийн чиглэл		Нөлөөллийн эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцалттай нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгаль экосистемийн өөрчлөлт											
1	Газрын доорх усны нөөц хомсдох	x				x		x		x	
2	Гадаргын усны урсац өөрчлөгдөх										
3	Ургамлын нөмрөг өөрчлөгдөх	x				x	x			x	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x	x			x	
5	Геологийн тогтоц өөрчлөгдөх										
6	Геоморфологийн нөхцөлд өөрчлөлт орох										
7	Амьтдын орон зайн өөрчлөлт гарах		x		x		x				x
8	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x		x		x			x
Байгалийн баялаг, нөөц ашиглалт											
1	Ашигт малтмалын нөөц баялаг хомсдох		x			x		x			x
2	Эрдэс, түүхий эдийн нөөц хомсдох		x			x		x			x
3	Бэлчээрийн талбай хомсдох										
4	Ургамлын нөөцөд нөлөөлөх	x				x	x				x
5	Ойн нөөцөд нөлөөлөх										
6	Ус намгархаг газарт нөлөөлөх										
7	Биологийн олон янз байдалд нөлөөлөх	x				x	x			x	
8	Эрчим хүчний нөөц	x				x	x				x

Байгаль орчны чанарын өөрчлөлт											
1	Газрын доорх усны чанар	x				x		x		x	
2	Гадаргын усны чанар										
3	Агаарын бохирдол	x			x		x			x	
4	Хөрсний бохирдол	x				x	x			x	
5	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x			x		x			x	
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
1	Байгалийн унаган төрх өөрчлөгдөх		x			x		x			x
2	Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх										
3	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
4	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
5	Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
Эдийн засаг, нийгмийн асуудал											
1	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх	+				+	+			+	
2	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+	+				+
3	Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
4	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+			+	
5	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x	x				x
6	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+	+				+
Бусад нөлөөлөл											
1	Химийн бодисын нөлөөлөл	x			x		x				x
2	Үнэрийн бохирдол /Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих/	x			x		x				x
3	Хүчтэй салхи шуурга, түймэр, газар хөдлөлт, аянга зэрэг байгалийн гамшгаас үүдэн аюул, осол гарах	x			x		x			x	
Дүн = 35		11/4	4/1	1	5/1	9/4	10/5	4	-	9/3	8/2
Хувь = 100%		71.5	23.8	4.7	31.5	68.5	79	21	0.0	54.5	45

Тайлбар: x - сөрөг нөлөөлөл

+ - эерэг нөлөөлөл

Байгаль орчинд үзүүлж болзошгүй 35 нөлөөллийг тодруулж авч үзвэл:

Нөлөөллийн хэлбэр

Шууд нөлөөлөл – “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй шууд нөлөөлөл 15 /71.5%/ байна. Шууд нөлөөллөөс 11 /73%/ нөлөөлөл сөрөг, 4 /27%/ нөлөөлөл эерэгээр нөлөөлнө. Төслийн үйл ажиллагааны явцад газрын доорх ус, ургамлан нөмрөг, хөрс, агаарт шууд сөргөөр нөлөөлөх талтай бол орон нутгийн эдийн засгийн байдал, ажлын байр нэмэгдэх зэрэгт шууд эерэгээр нөлөөлөхөөр байна.

Шууд бус нөлөөлөл - Үүнд 4 /23.8%/ төрлийн нөлөөлөл багтаж байна. Шууд бус нөлөөллөөс 4 /80%/ сөрөг, 1 /20%/ нөлөөлөл эерэгээр нөлөөлнө.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Болзошгүй нөлөөллийг үргэлжлэх хугацаагаар нь авч үзвэл богино хугацааны нөлөөлөл 6 /31.5%/, урт хугацааны нөлөөлөл 13 /68.5%/ байна. Нөлөөллийн ихэнх нь урт хугацааны нөлөөлөл байгаа нь төслийн хэрэгжүүлэх хугацаанд сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу байнга тасралтгүй хийж байх шаардлагатайг харуулж байна.

Нөлөөллийн чиглэл

Энэ хүрээнд нийт болзошгүй нөлөөллийг “буцалттай нөлөөлөл” болон “буцалтгүй нөлөөлөл” гэж 2 хэсэгт хувааж үзэв. Төслийн үйл ажиллагаанаас 15 /79%/ нөлөөлөл буцалттай буюу үр дагавар нь ирээдүйд арилах боломжтой нөлөөлөл байна. Нөгөө талаар энэ нь төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллүүд байгалийн нөхөн сэргэх боломжид сөрөг нөлөөлөл үзүүлэх нь бага байгааг харуулж байна. Харин нийт нөлөөллийн 4 /21%/ нь буцалтгүй нөлөөлөл байгаа бөгөөд тухайн өөрчлөгдсөн зүйлс эргэн хэвэндээ орохгүй чиглэлтэй байна. Байгаль орчинд сөргөөр, буцалтгүй байдлаар нөлөөлөл тохиолдолд түүнд сөрөг нөлөөлөл багатай үйл ажиллагааг төлөвлөн явуулах, үр ашигтай, хэмнэлттэй ашиглах нь зүйтэй.

Нөлөөллийн эрчим

Төслийн сөрөг нөлөөллийн эрчмийг тодорхойлсон хэсгээс үзэхэд нийт 35 нөлөөллөөс 55% буюу 12 нөлөөлөл дунд зэрэг, 45% буюу 10 нөлөөлөл бага зэрэг эрчимтэйгээр нөлөөлж байна. Төслөөс үзүүлэх хүчтэй сөрөг нөлөөлөл байхгүй байгаа ч дунд эрчимтэй, сөрөг нөлөөллүүдийг онцгойлон анхаарч, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ажлыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллавал сөрөг нөлөөллийн эрчмийг бууруулах, нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаа явуулах боломжтой юм. Төслөөс улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, ажлын байр шинээр бий болох, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх, тухайн нутаг дэвсгэрийн нийгэм-эдийн засагт дунд зэрэг, эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Б. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаа, байршил, төслийн технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг авч үзэхдээ магадлан жагсаах аргыг ашиглан түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохироход (0) нөлөөлөлгүй, (-) сөрөг нөлөөлөлтэй, (+) эерэг нөлөөлөлтэй гэж тэмдэглэв.

3.2.2. Байгаль орчны үнэлгээний нэгтгэл

“Алсын өртөө” ХХК-ийн “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг өмнөх хэсэгт авч үзсэнийг нэгтгэвэл 24 үзүүлэлтээр нөлөөллийн эрчмийг тодорхойлсноос төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нөлөөллийн 12.5% нь бага, 37.5% нь дунд, 25,0%, их 25% нөлөөлөлтэй байна. Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим байгаль орчны бусад бүрдэл хэсгүүдээс их байна.

Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, түүний үнэлгээ

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг					Үнэлгээ	
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Сүйрлийн	Тоо	Хувь
1	Эдэлбэр газарт үзүүлэх нөлөө	1	3	0	0	0	4	16,6
2	Агаарын чанарт үзүүлэх нөлөө	0	2	1	2	0	5	20,8
3	Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөө	2	0	2	0	0	4	16,6

4	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө	0	1	2	3	0	6	25
5	Ургамал, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө	0	0	1	1	0	2	8,5
6	Амьтны аймагт үзүүлэх нөлөө	0	3	0	0	0	3	12.5
Нөлөөллийн эрчим		3	9	6	6	0.0	24	100.0
		12.5%	37.5%	25.0	25.0	0.0		

Төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл:

“Алсын өртөө” ХХК-ийн “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв. Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл тус үйлдвэр, агуулахын төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

Хүснэгт 5. Болзошгүй сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар
<i>Агаар орчин</i>			
1	Тоосжилт (PM _{2.5} , PM ₁₀)	- Ажилчдын хөл хөдөлгөөн - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	- Улирлын чанартай. - Тархах хүрээ хязгаарлагдмал. - Салхины хурд бриксийн хурдас давах, агаарын температур их үед үүснэ.
2	Хийн хаягдал (Утаа, Угаар, SO, NO, CO)	- Хайлах зуух - Тээврийн хэрэгсэл, машин техник механизмын хөдөлгүүр	- Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал.
<i>Усан орчин</i>			
3	Усны нөөцийн хомсдол	- Унд ахуйн усны хэрэглээ - Технорргийн усны хэрэглээ	- Ажилчдын унд-ахуй ус хэрэглээ - Технологийн усны хэрэглээ
4	Хатуу болон шингэн хаягдал	- Ахуйн хог хаягдал - Технологийн хог хаягдал - Бохир ус дамжуулах шугам хоолойн гэмтэл, доголдол - Шатах тослох материалын хаягдал	- Гадаргын ус бохирдох бусад эх үүсвэрүүд - Газрын доорх усны бохирдолд өртөгдөх байдал - Удаан сарнина. - Гадаргын хэлбэршил
<i>Хөрсөн бүрхэвч</i>			
5	Элэгдэл, эвдрэл	-Тээврийн хэрэгсэл шороон замаар тээвэрлэлт хийх -Үйлдвэрлэлд ашиглагдах түүхий эдийн хадгалат -Хүний хөл хөдөлгөөнд байнга өртөж буй зам, жим дагтарших, талхлагдах -Дотоод зам талбайг зөв зохион байгуулах	- Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөлт орох. - Тархалтын хүрээ хязгаарлагдмал. - Тархалтыг хязгаарлах боломжтой. - Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой.
6	Бохирдол	- Ахуйн хог хаягдал - Шингэн хаягдал - Шатах тослох материалын асгаралт	- Тархах хүрээ хязгаарлагдмал. - Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана. - Хөрсний бохирдол шингээх хурд
<i>Ургамлан бүрхэвч</i>			
7	Ургамлан нөмрөг талхлагдах	-Ашиглалтын талбай, барилга байгууламжийн орчим	- Хэмжээ хязгаарлагдмал. - Ургамлын төрөл зүйл устах. - Ногоон байгууламж,

			тарималжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой.
<i>Нийгэм-эдийн засгийн орчин</i>			
10	Ажилчид	- Хүн амын эрүүл мэнд, ажил эрхлэх чадавх дээшилнэ.	- Хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө харьцангуй бага.
11	Үндсэн хөрөнгө	- Татварын эх үүсвэр	- Улсын төсөвт хувь нэмэр оруулна.
12	Шинэ ажиллагсад	- Ажлын байр бий болно.	- Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно.

Магадлан жагсаах аргаар тооцсон дүн

Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлсон дүнгээс үзэхэд тус төсөл нь байгаль орчинд нөлөөлөх байдлаараа “*дун-их*” нөлөөлөлтэй байна.

4. 2025 ОНД АШИГЛАХ ХИМИЙН БОДИС

буй “Алсын өртөө” ХХК-ийн “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанд 2025 онд 5 төрлийн 2.7 тонн химийн бодис ашиглахаар байна.

Хүснэгт 6. 2025 онд ашиглах химийн бодисын жагсаалт

№	Химийн бодисын нэр монгол	Химийн бодисын нэршил	Химийн томъёо	Жилд ашиглах хэмжээ
1	Борын хүчил	ortho-Boric acid; boracic acid; Borofax, boric acid	H_3BO_3	400кг
2	Ферромарганец, төмөрт марганец	Ferromanganese	$FeMn$	1 тн
3	Ферросилиций	Ferrosilicon	$FeSi$	1тн
4	Хүчилтөрөгч	Oxygen	O ₂	300 кг
5	Шингэн шилтн ккг тн	Sodium	Na_2SiO_3	200л

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго: “Алсын өртөө” ХХК-ийн “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төслийн үйл ажиллагааг явуулахдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум, орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

5.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Алсын өртөө” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 5 жилийн хугацаанд буюу 2024 оноос 2028 оны хугацаанд төлөвлөв. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй. БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11 сарын 1-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, мөн орон нутгийн засаг захиргааны байгууллага, хорооны иргэдэд танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

5.1.1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний

төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй болно.

5.1.2. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тус “Алсын өртөө” ХХК-ийн “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төсөл нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ширхэнцэг 2-р багийн нутагт дэвсгэрт хэрэгжиж байна. Төслийн талбай нь тусгай хамгаалалттай газар нутаг болон бусад газар ашиглагч нарын зөвшөөрөл бүхий газартай давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

5.1.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

5.1.4. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгалаа.

5.2. Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Алсын өртөө” ХХК-ийн “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Агаар орчин

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч сувилуулагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

Усны чанар

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөрсөн бүрхэвч

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.



Зураг 6. Орчны хяналт шинжилгээний цэгүүд



Зураг 7. Ногоон байгууламж, тарималжуулалт хийх байршил

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэл-тийн шалгуур Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	9	10
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Хийн хаягдал, тоосжилт	Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах	Агаарын чанар	3 цэгт	ОХШХ-Т Тусгагдсан			“Алсын өртөө” ХХК	Жилд 2 удаа	
Дуу чимээ			3 цэгт						
Гадаргын болон газрын доорх ус нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Ус ашиглалт	Усны төлбөр төлөх	Гадаргын болон гүний усны нөөц, чанар	Усны нөөц хэмнэх	Гэрээний дагуу тоолуурын заалтаар төлбөр төлөх	-		“Алсын өртөө” ХХК	Тогтмол	“Усны тухай хууль” “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль”
Ус ашиглалт	Төсөл хэрэгжүүлэгч нь Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журмыг мөрдөж тус журмын дагуу тоолуур суурилуулах. Гүний худаг болон цэвэр бохир усны оролт гаралт бүрт усны тоолуур суурилуулж баталгаажуулах шаардлагатай	Усны нөөц хэмнэх	Иж бүрэн	1.000.000		“Алсын өртөө” ХХК	Нэг удаа		
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох	Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх	Хөрс хамгаалал	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой			“Алсын өртөө” ХХК	Тогтмол	MNS 5342:2007. MNS 4048-88 MNS 4585-2016 MNS ISO 4227 : 2002 MNS 3113 : 1981 MNS 5028 : 2001	
	Эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх,	Хөрс, ургамлан нөмрөг	2.000.000			“Алсын өртөө” ХХК	Тогтмол		
Хөрс элэгдэх, ургамлан	Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.			“Алсын өртөө” ХХК	Тогтмол		

нөмрөг талхлагдах	зориулалтын цэгт хогийн сав байршуулах	Хог хаягдлын менежмент	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.				“Алсын өртөө” ХХК	Тогтмол	MNS 3297:1991 MNS 4919:2000 MNS 4920:2000 MNS 3297:1991 MNS 4919:2000 MNS 4920:2000
	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ сумын ТҮК-тэй гэрээ байгуулах								
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ									
БОННУ-ний тайлангийн БОМТ-ны хэрэгжилтийн талаар нутгийн иргэдэд тайлагнах		Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд	багц	3	-	-	“Алсын өртөө” ХХК	Сумын засаг дарга, ИНХ- ын дарга	БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам
Нийт					3.000.000				

7. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт
Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох	Орчны тохижилтыг сайжруулан төслийн талбайд ногоон байгууламж хийх	Агч	Ширхэг	3	28.000	84.000	Төсөл хэрэгжих хугацаанд	- Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт - MNS5914:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт.MNS5916:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага.
		Улиас	Ширхэг	5	20.000	100.000		
		Нийт		8	48.000	184.000		
Ногоон байгууламж байгуулах зардал		Шаардагдах техник, хэрэгсэл				20.000		
		Бордоо				250.000		
		Хар шороо				60.000		
		Арготехникийн ажиллагаа				360,000		
		Ажилчдын хөлс				-		
Арчилгаа, тордлогоо	Ногоон байгууламжийн усалгаа тайралт, хэлбэржүүлэлт хийх	Төслийн талбайд				140.000	Төсөл хэрэгжих хугацаанд	
Нийт дүн 1.014.000								

8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө							
Ахуйн болон химийн аюултай хатуу хог хаягдал	Ахуйн хог хаягдал түр хадгалах сав байгуулах, хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх	Үйлдвэрийн хашаанд	1 ш/удаа	-	2.000.000	“Алсын өртөө” ХХК	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” “Хог хаягдлын тухай хууль”, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр, БОАЖ сайдын 2018.11.17 өдрийн А/443 дугаар тушаал Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах,тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
	Хатуу хог хаягдлыг ангилан ялгах менежментийг сайжруулах, ажилчдад сургалт зохион байгуулах	Төслийн хүрээнд	Улиралд 1 удаа	Зардал тусгах шаардлагагүй.		“Алсын өртөө” ХХК	
	Химийн бодисын сав баглаа боодлыг аюулгүй зайлуулах, устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	Төсөл хэрэгжих бүх үе шатанд	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу төлөх. Үйл ажиллагааны зардалд тусгах		“Алсын өртөө” ХХК	
	Химийн бодисын сав баглаа боодлыг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн мэдээллийн сан, бүртгэл үүсгэх	Төслийн хүрээнд	Төсөл хэрэгжих бүх үе шатанд	-		“Алсын өртөө” ХХК	
	Үйлдвэрийн дотоод орчинд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Үйлдвэрийн дотоод орчин	10 ш	500.000		“Алсын өртөө” ХХК	
	Хог хаягдлыг ангилан ялгаж тэсдэг тэсдэглэгээ, хаяг, хог хаягдлыг ангилан ялгах тухай мэдээллийн самбар байгуулах	Хогийн сав	-	100.000		“Алсын өртөө” ХХК	
Хог хаягдал хуримтлагдах	Төслийн талбай орчныг бохирдуулахаас сэргийлж, хорооны холбогдох байгууллагатай хамтран ойр орчимд тогтмол цэвэрлэгээ хийж байх	Ойр орчмын 50 метр газарт	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		“Алсын өртөө” ХХК	
Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Тухай бүрт нь	-	Зардал тусгах шаардлагагүй.	“Алсын өртөө” ХХК	
Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хатуу хог хаягдлын цэгт	Улирал бүр 1 удаа	Холбогдох байгууллагатай хийсэн гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр		“Алсын өртөө” ХХК	
Нийт зардал			2.600.000 төгрөг				

9. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Гүйцэтгэгч	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Химийн бодисын ашиглалт, хадгалалтын үе шат					
ХБ-ын хадгалалт, ашиглалтын явцад асгарах, ХХД алдагдснаар ажиллансдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	ХБ-той ажиллах ажиллагсдыг хөдөлмөр хэрэгслээр бүрэн хангах	-	Тогтмол	“Алсын өртөө” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” MNS 5029:2011 MNS 6458:2014 MNS /ISO/ 13688:2000
	Ажилчдад химийн бодистой харьцаж ажиллах зааварчилгаа, сургалт явуулах	100.000	Жилд нэг удуу		
	Вермикулят, шингээгч материалыг бэлэн байлгаж, яаралтай арга хэмжээ авах төлөвлөгөөтэй байх, орон нутгийн онцгой байдлын газарт мэдэгдэх	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Тухайн нөхцөл бүрдсэн үед		
Ослын эрсдлээс урьдчилан сэргийлэх					
Химийн бодисын агуулахын битүүмжлэл алдагдаж, агаар, ус, хөрсөөр тархах, ХБ-ын ашиглалтын үед асгарч алдагдах	ХБ-т өртсөн үед яаралтай тусламж үзүүлэх хэрэгсэл, эмийн сан бий болгож, тодорхой газар байрлуулах	50.000	Химийн бодисын ашиглалтын бүх хугацаанд	“Алсын өртөө” ХХК	“Гамшгаас хамгаалах тухай хууль” “Галын аюулаас урьдчилан сэргийлэх заавар”
Нийт зардал			150.000 төгрөг		

10. АЖИЛЧДЫН ЭРҮҮЛ МЭНДЭД УЧРУУЛАХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Бүх ажиллагсдыг мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах	Жилд 1 удаа	10 Ажилчид /1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		“Алсын өртөө” ХХК	Мэргэжлийн байгууллага		-
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сурталчилгааг тогтмол хийж байх, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай ажилчид танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	Өдөр бүр	-	-	-	“Алсын өртөө” ХХК	ХАБ ажилтан		MNS 4969:2000
Ажилчдад өглөө бүр аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилтныг аюулгүй ажиллах арга барилд байнга сургаж байх	Аюулгүй ажиллагаа	Өдөр бүр	-	-	Зардал тусгах шаардлагагүй	“Алсын өртөө” ХХК	ХАБ ажилтан		MNS 4969:2000
Ажлын байрны гэрэлтүүлгийг жигд хүрэлцээтэй тусаж байхаар ерөнхий болон хэсгийн гэрэлтүүлгийг сайжруулах	Аюулгүй ажиллагаа	1 удаа	ш	-	-	“Алсын өртөө” ХХК	Мэргэжлийн байгууллага	АҮК өндөртэй, байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмж сонгох	MNS 4996:2000
Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001” стандартыг мөрдөж ажиллах	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Тогтмол	-	-	Зардал тусгах шаардлагагүй	“Алсын өртөө” ХХК	ХАБ ажилтан		MNS 5080:2001
Нийт									

11. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, төгрөг	2025	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	-		“Алсын өртөө” ХХК	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дагаж мөрдөх
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	100.000	+	Захирал Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани	Ажилчдад байгаль орчныг хамгаалах мэдлэг олгох, байгаль болон үйл ажиллагаанаас үүсэн гарах гэнэтийн осол эрсэлээс сэргийлэх зэрэг мэдлэг олгох зорилгоор сургалт зохион байгуулах. 20234 онд 1 удаа, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах боломжтой.
3	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардалд тусгах		“Алсын өртөө” ХХК	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр
4	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх	600.000		“Алсын өртөө” ХХК	Ажиллагсдыг мэргэжлийн эмчийн үзлэгт тогтмол харуулж ажиллах
5	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Нийслэлийн ЗДТГ-г хүргэн өгч байх	-		“Алсын өртөө” ХХК	-
6	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөр	Дотоод зардлаар		“Алсын өртөө” ХХК	“Газрын төлбөрийн тухай хууль”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийг дагаж мөрдөх
7	Химийн бодисын сав баглаа боодлыг устгах “Химийн хортой болон аюултай бодисын хаягдлыг устгах байгууллагын дотоод журам” боловсруулах, химийн бодис болон авултай хог хаягдлын бүртгэл, мэдээллийн сан үүсгэх	-		“Алсын өртөө” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль
8	Химийн бодисын үлдэгдлийн тайлан, мэдээг БОАЖЯ-нд жил бүр хүргүүлж тайлагнаж байх	-		“Алсын өртөө” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль
9	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах, ашиглах зөвшөөрөл авах	-		“Алсын өртөө” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль

10	Химийн бодисын сав баглаа боодлыг аюулгүй зайлуулах, устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу төлөх. Үйл ажиллагааны зардалд тусгах		“Алсын өртөө” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль
11	Хог хаягдлын гэрээ байгуулах Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх	-		“Алсын өртөө” ХХК	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
12	Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан сумын иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдэж өгөхөд дэмжиж туслах, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах	-		“Алсын өртөө” ХХК	
13	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах	-		“Алсын өртөө” ХХК	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
14	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу зайлуулах	-		“Алсын өртөө” ХХК	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
Ний 1.400.000					

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт
АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
1.2.	Хорт хийн агууламж: Азотын давхар исэл (NO ₂) Хүхэрлэг хий (SO ₂) Нүүрстөрөгчийн давхар исэл (CO ₂), дутуу исэл CO, HCN, O ₂	мкг/м ³	Төслийн талбайн гадаа, Түүхий эд материалын хажууд, Нүүрс буулгах цэг	5 болон 10-р сард буюу жилд 2 удаа	160.0	960.0	“Алсын өртөө” ХХК	Мэргэжлийн байгууллага, судлаач	MNS 4585:2016. MNS 3384:1982. MNS 4048:1988. MNS 0017-2-5-11:1988. MNS 5013:2009. MNS 5014:2009. MNS 5002:2000.
1.3.	Агаарын тоос тоосонцор (PM _{2.5} , PM ₁₀)	мкм	Бохирдол үүсэх эх үүсвэр орчимд 1 цэгээс дээж авах Хатуу хог хаягдлын цэгийн ойролцоо 1 цэг Нүүсний агуулахын хажууд	5 болон 10-р сард буюу жилд 2 удаа	100.0	600.0	“Алсын өртөө” ХХК		
1.4	Халаалтын зуухнаас гарсан хаягдал үнснээс шинжилгээ авах	мкм	Үнс түр хадгалах цэгээс	Жилд 2 удаа	100.0	200.0	“Алсын өртөө” ХХК		
1.5	Хаягдал үнсний цацрагийн хэмжилт			Жилд 2 удаа	100.0	200.0	“Алсын өртөө” ХХК		
УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
2.1.	Усны химийн шинжилгээ Био идэвхит нэгдлүүд Нян судлалын үзүүлэлт: Нянгийн тоо Гэдэсний бүлгийн савханцар Эмгэг төрөгч бактери	мг/дм ³	Унд-ахуйн ус	5 болон 10-р сард буюу жилд 2 удаа	100.0	200.0	“Алсын өртөө” ХХК	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори, УЦУОШГ	MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-2:2002: MNS 4867-1999: УСТ-3534-1983 MNS 0900:2005 MNS 4685:1998
		1 мл-г илрүүлэх 100 мл-г							
ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
3.1.	Хөрсний физик, агрохимийн үндсэн үзүүлэлтүүд: Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим	мг	Бохирдол үүсэх эх үүсвэр орчимд 1 цэгээс дээж авах				“Алсын өртөө” ХХК	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори,	MNS 3298:1991. MNS 5850:2008. MNS 3985-87. MNS 3310-91. MNS 2305-94. MNS 2305:1994.
3.2.			Хатуу хог хаягдлын цэгийн ойролцоо 1 цэг Нүүрс буулгах цэг	5 болон 10-р сард буюу жилд 2 удаа	150.0	900.0	“Алсын өртөө” ХХК		

	тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O) Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co/		Нийт 3 цэг					Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораториуд	
ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ									
4	Дуу шуугиан	дБА	Агуулахын талбай орчимд 2 цэгт	10-р сард буюу жилд 2 удаа	50.0	200.0	“Алсын өртөө” ХХК	Хорооны эрүүл мэндийн байгууллага	MNS 5002:2000 MNS ISO 226:2003
1 жилийн ОХШХ-ийн нийт зардал /мян.төг/						3.260.0			

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ							
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Хэрэгжүүлэгч	“БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам” Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд
Дүүргийн байгаль орчны газар	Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 1-ний дотор	Шинжээчдийн дүгнэлт	Дүүргийн байгаль орчны газар	“Алсын өртөө” ХХК	
Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор	БОХ арга хэмжээний тайлан, ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах	Дүүрэг, хороо	“Алсын өртөө” ХХК	
Төрийн бус байгууллагууд, олон нийт			Жил бүр 1 удаа		Тухайн үед сонгох	“Алсын өртөө” ХХК	
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр		12-р сарын 10-ний дотор	Хянуулах батлуулах	Улаанбаатар хот	“Алсын өртөө” ХХК	

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ						
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцох талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
БОУАӨЯ, ХБОВХГ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Жил бүр 1 удаа	-	-	“Алсын өртөө” ХХК
БОУАӨЯ, ХБОВХГ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Тухайн жилийн 11-12 сарын дотор	-	-	

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2025 оны зардлыг дараах хүснэгтэд харуулав.

Зардлын хэлбэр	Нийт зардал, төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	3.000.000
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1.014.000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	2.600.000
Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	150.000
Осол, эрсдэлийн төлөвлөгөөний зардал	-
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	700.000
БОМТ-г хэлэлцүүлэх, тайлагнах зардал	-
Орчны хяналт шинжилгээний зардал	3.260.000
Нийт	10,724,000

“Алсын өртөө” ХХК-ийн “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **10.724.000** (Арван сая долоон зуун хорин дөрвөн мянга) төгрөг болж байна.

15. ДҮГНЭЛТ

“Алсын өртөө” ХХК-ийн “Хаягдал төмөрлөг боловсруулах үйлдвэр” төсөл нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ширхэнцэг 2-р багийн нутагт хэрэгжиж байна. Төслийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулж буй “Алсын өртөө” ХХК нь тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **10.724.000** төгрөг зарцуулагдах урьдчилсан дүн гарсан байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн бичиг баримт юм.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа БОУАӨЯ, аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлэх шаардлагатай.